

**Төрийн албан хаагчдын монгол бичгийн мэдлэг, чадварыг тодорхойлох
сорилын нийцлийн шинжилгээний үр дүн**

Жамбалжавын ГЭРЭЛМАА*

*Монгол Улс, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн
Монгол хэл бичгийн судалгаа, арга зүйн төв*

Received: Oct 1, 2023

Revised: Nov 20, 2023

Accepted: Dec 14, 2023

Хураангуй: Монгол бичгийн хэрэглээнд албан ёсоор шилжих дунд болон урт хугацааны төлөвлөлтийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлын хүрээнд төрийн албан хаагчдын монгол бичгийн мэдлэг, чадварын түвшнийг тогтооход ашиглах сорилын нийцлийг шинжлэх судалгааны үр дүнг энэхүү өгүүлэлд тусгав. Төрийн албан хаагчдын монгол бичгийн мэдлэг, чадвар ямар түвшинд байгааг судалгаагаар тогтоож, түүнд тулгуурлан дэмжих чиглэл, үйл ажиллагааны арга хэлбэрийг тодорхойлох юм. Мөн энэхүү судалгааны эрдэм шинжилгээний болон практик ач холбогдлыг бид дараах байдлаар тодорхойлж байна.

- Монгол бичиг үсгийн боловсролын онол, арга зүйг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулна.
- Насанд хүрэгчдийн бичиг үсгийн (монгол бичгийн) боловсролын үзэл санаа, ойлголт төлөвшинө.
- Монгол бичгийн эрдэм шинжилгээний арга хандлагын талаар системтэй мэдлэг бий болоход хувь нэмэр оруулна.
- Монгол бичиг үсгийн боловсролын талаарх судалгааны материалыг эрдэм шинжилгээний эргэлтэд оруулах боломж бүрдэнэ.
- Турших судалгааны явцад боловсруулсан хөтөлбөр, гарын авлага, сургалтын хэрэглэгдэхүүн, ашиглах арга аргачлалыг ашиглах боломжтой.
- Монгол бичгийн насанд хүрэгчдийн сургалтын нэгдсэн системчилсэн (хөтөлбөр, гарын авлага, сургагч багш, цахим болон цаасан хэрэглэгдэхүүн) багц туршигдаж бэлэн болсноор зорилтот бүлгүүд чадавхжиж хүний нөөц бий болно.
- Мэдээллийн сан, түвшинчилсэн сорилын сан, судалгааны өгөгдлийн сантай болно.

* © Ж.Гэрэлмаа
Email: g_t_a@mier.mn

Түлхүүр үг: монгол бичиг, түвшин, даалгавар, шинжилгээ, арга, хүчин зүйлс

The Results of Compliance Test for Determining the Mongolian Script Knowledge and Skills of Civil Servants

GERELMAA Jambaljav

Research and Methodology Center for Mongolian Philology of the Mongolian National Institute of Educational Research, Ulaanbaatar, Mongolia

Abstract: *In the framework of conducting the preparatory work for the implementation of the medium and long-term planning of the official transition to the use of the Mongolian script, the results of the analysis of the test used to determine the level of knowledge and ability of government employees in the Mongolian script are reflected in this article. The study will determine the level of knowledge and skills of the government employees in Mongolian script, and based on that, the directions and forms of activities will be determined. Also, this study is academically and practically important on the following points.*

- *Contribute to the development of Mongolian literacy education theory and methodology.*
- *Ideas and understanding of adult literacy (Mongolian script) education will develop.*
- *Contribute to the creation of systematic knowledge about the research methods of Mongolian script.*
- *It will be possible to put research materials on Mongolian literacy education into academic circulation.*
- *It is possible to use the programs, manuals, training materials, and methods developed during the pilot study.*
- *Once the comprehensive and systematic procedure of Mongolian script for adults (programs, manuals, trainers, electronic and paper materials) is tested and ready, the target groups (public servants) will be upskilled and human resources will be increased in the field.*
- *As a result of the study, a database, standardized test database, and research database will be created.*

Keywords: *mongolian script, level, task, analysis, method, factors.*

1. Удиртгал

Монгол хэлний тухай хуулийн 13.1.1 (УИХ, Монгол хэлний тухай хууль, 2015); Боловсролын тухай хуулийн 10.3 (УИХ, Боловсролын тухай хууль, 2002); Алсын хараа-2050-ийн 1.3 (УИХ, Алсын хараа 2050, 2020); Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III-ын 2.3 (МУЗГ, 2020); Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 1.3-т (УИХ, Монгол улсыг 2021-2025

онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай, 2020) үндэслэн *Бүх нийтийн монгол хэл, бичгийн хэрэглээ, хандлага, үнэлэмжийн судалгаа I-ийг 2022* (ХБҮЗ, 2022) онд хийсэн байна. Энэхүү судалгаагаар төрийн албан хаагчдын монгол бичгийн мэдлэг, чадварын түвшнийг асуулгын аргаар, өөрийн үнэлгээнд тулгуурлан тодорхойлсон юм. Монгол бичгийн мэдлэг чадварын түвшнийг асуулгаар илрүүлэх нь бодит үр дүнг тооцоход хангалтгүй гэж үзсэн учраас сорилын мэдээлэл цуглуулж төрийн албан хаагчдын монгол бичгийн мэдлэг, чадварыг тодорхойлох, гүйцэтгэлд нөлөөлж байгаа хүчин зүйл болон дэмжих боломжийг илрүүлэхээр энэхүү судалгааг хийсэн болно.

Судалгааны баг боловсролын салбарын төрийн албан хаагчдын монгол бичгийн мэдлэг, чадварыг тогтоох сорил боловсруулах, сорилын нийцлийн шинжилгээг хийхдээ үндэсний мэргэжилтэн, багш нарын багтай хамтран ажилласан юм.

1.1. Судалгааны зорилго

Төрийн албан хаагчийн монгол бичгээр баримт бичиг төлөвлөх, боловсруулах, албан хэрэг хөтлөх, цахим орчинд хэрэглэх мэдлэг, чадварыг тогтоох сорилын сан бүрдүүлэхэд оршино. Энэхүү зорилгын хүрээнд дараах зорилтуудыг тавьсан. Үүнд:

1. Төрийн албан хаагчдын монгол бичгийн чадварыг тодорхойлох сорилын сан бүрдүүлнэ.
2. Сорилын нийцлийг тогтооно.
3. Судалгаанд хамрагдсан албан хаагчдын монгол бичгийн мэдлэг чадварыг тандан судална.
4. Насанд хүрэгчдийн монгол бичгийн түвшин тогтоох сургалтын жишиг загвар боловсруулах боломж, түүнийг нэвтрүүлэх арга замыг тодорхойлно.

1.2. Онолын үндэслэл

Энэ судалгаагаар бид төрийн албан хаагчдаас авсан сорилын найдвартай байдал болон даалгавруудын нийцлийг *Тестийн сонгодог онол*-д үндэслэн илрүүлэх зорилго тавилаа. Тестийн сонгодог онол (Classical Test Theory) нь шалгалттай холбоотой хийдэг хамгийн хялбар бөгөөд түгээмэл хэрэглэгддэг анализ юм. Шалгалт, даалгавар, сорилд оролцогчдын чадвартай холбоотой олон төрлийн судалгааг Тестийн сонгодог онол (Classical Test Theory) болон даалгаврын хариултын онолоор (Item Response Theory) судалдаг. Уламжлалт онолд шалгалт болон даалгаварт анализ хийхдээ тухайн шалгалтын найдвартай байдлын коэффициент (reliability coefficient) болон даалгаврын ялгах чадварын индекс (item discrimination index) гэдэг гол хоёр үзүүлэлтийг ашигладаг (Шинэтуяа, Амарзаяа, 2021). Тестийн сонгодог онолын талаар маш олон судалгаанууд байдаг бөгөөд ихэвчлэн анхны оноо (raw score) болон даалгаврын найдвартай байдал гэх мэт тестийн оноотой холбоотой хүчин зүйлд түшиглэдэг бол даалгаврын хариултын онол нь даалгаврын хүндрэл гэх мэт даалгавартай

холбоотой хүчин зүйлд тулгуурладаг. Даалгаврын хариултын онол нь тесттэй холбоотой хэмжигдэхүүнүүдийг судлахад илүү давуу талтай байдаг бөгөөд тестийн даалгаврын илэрхий хариултаас хамаарч сорилд оролцогчдын илэрхий бус чадварыг харуулж өгдөг учраас нуугдмал чанарын онол ч гэж нэрлэгддэг.

1.3. Судалгааны арга зүй

Монгол хэлний тухай хуулийн “Үндэсний бичгийн хөтөлбөрийг үе шаттай хэрэгжүүлж, зохих бэлтгэл хангасны үндсэн дээр төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага албан хэргээ кирилл болон үндэсний хос бичгээр хөтлөн явуулна” гэсэн заалт болон монгол хэл, бичиг үсгийн хэрэглээг нэмэгдүүлэх, хамгаалах, хөгжүүлэх, үндэсний бичгийн хэрэглээнд албан ёсоор шилжих дунд болон урт хугацааны үндэсний хөтөлбөр, дүрэм, журмыг үндэслэн МУЗГ-ын тогтоолоор *Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-III*-ыг боловсруулан баталж 69 үйл ажиллагааг төлөвлөжээ.

Энэ хүрээнд Хэлний бодлогын үндэсний зөвлөлөөс *Төрийн албан хаагчдын монгол бичгийн мэдлэг тодорхойлох судалгаа-I*-ийг зохион байгуулсан нь бидний судалгааны суурь түвшин болсон юм.

Хөмрөг шинжилгээний арга, тооцооллын арга, цахим сорилын арга, асуулга, статистик шинжилгээний арга (SPSS-25 программ)-ыг тус тус ашиглав.

Төрийн албан хаагчийн албан хэрэг хөтлөлтөд зайлшгүй шаардлагатай мэдлэг, чадварыг илрүүлэхдээ боловсролын салбарын багш болон бусад албан хаагчдын бүлэг үүсгэн мэдээлэл цуглуулав. Судалгааны үр дүнд боловсролын салбарын төрийн албан хаагчдын монгол бичгийн мэдлэг, чадварын түвшнийг тогтоох сорилын нийцлийн шинжилгээтэй уялдуулан тэдний гүйцэтгэлийг тандаж, үндсэн судалгааг (Бид энэхүү судалгааг 2024 онд хийхээр төлөвлөж байна.) салбарын хэмжээнд хэрэгжүүлэхэд шаардлагатай зүйлсийг тодруулав.

2. Судалгааны хэсэг

2.1 Мэдээлэл цуглуулах явц

Энэхүү судалгааны хувьд даалгаврын сонгодог онол (СТТ) нь алдааны тоон үзүүлэлтийг тодорхойлох, хувьсагчдын хоорондын хамаарлыг (жишээ нь, корреляци) засах зэрэг асуудлыг шийдвэрлэхэд зориулагдсан болно (Отгонбаатар, 2016). СТТ-ийн үндсэн ойлголтууд нь авах ёстой оноо ба алдааны хувьсагч юм. Даалгаврыг шинжлэхдээ даалгавар тус бүрийн хүнд хөнгөний зэрэг, ялгах чадвар, хамаарлын коэффициент, найдвартай байдлыг тооцов.

Судалгааны үр дүнд боловсролын салбарын төрийн албан хаагчдын монгол бичгийн мэдлэг, чадварын түвшнийг тогтоох сорилын нийцлийн шинжилгээтэй уялдуулан тэдний гүйцэтгэлийг тандаж, үндсэн судалгааг (Бид энэхүү судалгааг 2024 онд хийхээр төлөвлөж байна) салбарын хэмжээнд хэрэгжүүлэхэд шаардлагатай зүйлсийг тодруулав.

2.2. Судалгааны үр дүнгийн талаар

Сорилын үгийн санг бүрдүүлэхдээ албан баримт бичгийн шинжилгээ хийж, өндөр давтамжтай үгсийн жагсаалт гаргаж, ашигласан болно. Ингэхдээ монгол бичгийг ямар зорилгоор сурч, ашиглах эсэхийг харгалзсан ба албан бичиг баримт боловсруулалтын хэрэглээнд түгээмэл ашигладаг үгсийг оруулахыг чухалчилсан юм. Албан хэрэгт өргөн ашигладаг үгсийн жагсаалтыг захирамжлал, зохион байгуулалт, мэдээлэл, лавлагааны бичиг баримтаас зарлиг, тушаал, захирамж, албан шаардлага, шийдвэр, тогтоол, зөвлөмж, гэрээ, тайлан, акт, илгээлт, төлөвлөгөө, мэдэгдэл, илтгэл, танилцуулга, илтгэх хуудас, мэдээлэл, тодорхойлолтыг сонгон тус бүрээс тав тавыг төлөөлүүлж, үндсэн хууль болон бусад салбарын 10 хуулийг сонгон үгсийн давтамжийн судалгааг хийлээ. Нийт 600,000 үгийн сан хөмрөг бүрдүүлж, үгсийн давтамжийг тооцоолон гаргаж, үгсийг толгойлон бүлэглэсний зэрэгцээ, гадаад үг, нөхцөл, товчилсон нэр томъёог ялгаж, ангилав.

Хүснэгт 1. Өндөр давтамжтай үгс

1	хол	6596	ᠬᠣᠯ	33	хан	1870	ᠬᠠᠨ	65	байгаль	1338	ᠪᠠᠶᠢᠭᠠᠯ
2	хууль	5079	ᠬᠡᠭᠦᠯ	34	зам	1832	ᠵᠠᠮ	66	дагуу	1323	ᠳᠠᠭᠤᠭᠠ
3	тухай	4162	ᠲᠤᠬᠠᠢ	35	өдөр	1827	ᠥᠳᠦᠷ	67	хот	1306	ᠬᠣᠲ
4	он	4112	ᠣᠨ	36	үйл	1815	ᠦᠶᠢᠯ	68	хамгаал-	1300	ᠬᠠᠮᠭᠠᠯ
5	болон	3460	ᠪᠣᠯᠣᠨ	37	хяна-	1773	ᠬᠢᠨᠠ	69	түүн-төр	1278	ᠲᠡᠭᠦᠨ
6	бай-	3417	ᠪᠠᠶ	38	хөгж-	1738	ᠬᠡᠭᠢᠵ	70	алба	1241	ᠠᠯᠪᠠ
7	энэ	3397	ᠡᠨᠢ	39	хэсэг	1709	ᠬᠡᠰᠡᠭ	71	ашигла-	1216	ᠠᠰᠢᠭᠢᠯᠠ
8	газар	3327	ᠭᠠᠰᠠᠷ	40	зөвшөөрөл	1702	ᠵᠥᠪᠰᠡᠬᠡᠭᠡᠷᠦᠯ	72	нийт	1190	ᠨᠢᠶᠲᠤ
9	ажил	3138	ᠠᠵᠢᠯ	41	колбоо	1696	ᠬᠣᠯᠪᠤᠭᠠ	73	бодлого	1189	ᠪᠣᠳᠯᠣᠭᠠ
10	заа-	3053	ᠵᠠᠭᠠ	42	байдал	1667	ᠪᠠᠶᠳᠠᠯ	74	хүлээ-	1188	ᠬᠦᠯᠡᠭᠡ
11	хугацаа	2929	ᠬᠤᠭᠠᠴᠠᠭᠠ	43	төсөл	1609	ᠲᠥᠰᠡᠯ	75	журам	1176	ᠵᠢᠷᠠᠮ
12	хувь	2899	ᠬᠤᠪᠦ	44	үндсэн	1596	ᠦᠨᠳᠦᠰᠢᠨ	76	хүчин	1176	ᠬᠦᠴᠢᠨ
13	ав-	2723	ᠠᠪ	45	ажилла-	1581	ᠠᠵᠢᠯᠠ	77	асуудал	1174	ᠠᠰᠤᠭᠠᠳᠠᠯ
14	хөдөл-	2550	ᠬᠡᠳᠡᠯ	46	хөтөл-	1562	ᠬᠡᠲᠡᠯ	78	жил	1172	ᠵᠢᠯ
15	хэмж-	2512	ᠬᠡᠮᠵ	47	мэдээлэл	1560	ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ	79	өөрчил-	1169	ᠥᠡᠷᠴᠢᠯ
16	гэрээ	2483	ᠭᠡᠷᠡᠭᠡ	48	шийд-	1556	ᠰᠢᠶᠢᠳ	80	тус	1161	ᠲᠤᠰ
17	байгууллага	2482	ᠪᠠᠶᠭᠤᠭᠤᠯᠠᠭᠠ	49	орчин	1475	ᠣᠷᠴᠢᠨ	81	хүр	1157	ᠬᠦᠷ
18	бол-	2448	ᠪᠣᠯ	50	захь-	1460	ᠵᠠᠬᠢ	82	дүгээр	1149	ᠳᠦᠭᠡᠷ
19	дугаар	2441	ᠳᠤᠭᠠᠭᠠᠷ	51	нэг	1460	ᠨᠡᠭ	83	ол-	1136	ᠣᠯ
20	тал	2419	ᠲᠠᠯ	52	төр-	1457	ᠲᠥᠷ	84	их	1116	ᠶᠢᠬᠡ
21	хөрөнгө	2314	ᠬᠥᠷᠦᠨᠭᠡ	53	ор-	1447	ᠣᠷ	85	худал	1110	ᠬᠤᠳᠠᠯ
22	ажиллагаа	2294	ᠠᠵᠢᠯᠠᠭᠠᠭᠠ	54	тусгай	1437	ᠲᠤᠰᠭᠠᠢ	86	иргэд	1108	ᠢᠷᠭᠡᠳ
23	засаг	2292	ᠵᠠᠰᠠᠭ	55	бусад	1434	ᠪᠤᠰᠠᠳ	87	хариу	1108	ᠬᠠᠷᠢᠭᠠ
24	хий-	2286	ᠬᠢᠶ	56	гэ-	1430	ᠭᠡ	88	олон	1103	ᠣᠯᠣᠨ
25	зохиогч	2250	ᠵᠣᠬᠢᠣᠭᠴᠢ	57	гарга-	1427	ᠭᠠᠷᠭᠠ	89	бол	1092	ᠪᠣᠯ
26	хэрэг	2194	ᠬᠡᠷᠦᠭ	58	үйлчилгээ	1416	ᠦᠶᠢᠯᠴᠢᠯᠭᠡ	90	хэл	1069	ᠬᠡᠯ
27	хэрэгж-	2152	ᠬᠡᠷᠦᠭᠢᠵ	59	зориг	1405	ᠵᠣᠷᠢᠭ	91	зар-	1065	ᠵᠠᠷ
28	зүйл	2128	ᠵᠡᠶᠢᠯ	60	нэм-	1385	ᠨᠡᠮ	92	орон	1054	ᠣᠷᠣᠨ
29	сар	2022	ᠰᠠᠷ	61	арга	1365	ᠠᠷᠭᠠ	93	эрүүл	1047	ᠡᠷᠦᠭᠦᠯ
30	эрх	1996	ᠡᠷᠬ	62	гүйц-	1365	ᠭᠡᠶᠢᠴ	94	хороо	1032	ᠬᠣᠷᠠᠭᠠ
31	хүн	1986	ᠬᠦᠨ	63	үүрэг	1341	ᠦᠦᠷᠦᠭ	95	зөвлөл	1025	ᠵᠥᠪᠯᠡᠯ
32	монгол	1947	ᠮᠣᠩᠭᠣᠯ	64	батал-	1340	ᠪᠠᠲᠠᠯ				

2.3. Сорилын боловсруулалт

Анхан, дунд, ахисан түвшний 800 сорилыг бюпринтийн дагуу боловсруулав. Үүнд, эгшиг, гийгүүлэгч үсэг 100, дэвсгэр үсэг, тоо, зарим гийгүүлэгч 100, гадаад үсэг, үг 100, нэрийн хувилал 100, үйлийн хувилал 100, урт, хос эгшиг 100, нэр, үйл үгийн үндэс 100, албан бичгийн найруулга 100 сорилын даалгавар, нийт 800 сорилын сан бүрдүүлсний зэрэгцээ, сорилыг танин мэдэхүйн түвшин, агуулгын түвшин, даалгаврын тавилаар бүлэглэв. Тухайлбал,

- Танин мэдэхүйн түвшнээр: Сэргээн санах, ойлгох, задлан шинжлэх, хэрэглэх, үнэлэх, бүтээх.
- Агуулгын түвшнээр: Анхан, дунд, ахисан шат.
- Даалгаврын төрлөөр: Сонгох, харгалзуулах, хөрвүүлж нөхөх гэх мэт.

2.4. Асуулгын мэдээллийн үр дүн

Судалгаанд 143 нь эрэгтэй, 527 нь эмэгтэй, нийт 670 хүн оролцсон байна. Насны хувьд 36-45 насныхан хамгийн их хамрагдсан бол, ажилласан жилийн хувьд 0-5 жил ажиллаж буй багш 163; 6-10 жил ажиллаж байгаа 105; 11-15 жил ажиллаж буй 109 бол, 16 ба түүнээс дээш жил ажиллаж байгаа багш, ажилтан 168 байна.

Даалгаврын гүйцэтгэлийг ажилласан жилтэй харьцуулан үзэхэд, ажилласан жил нэмэгдэх тусам гүйцэтгэл сайжирсан үзүүлэлттэй байна ($P < 0.01$). Тухайлбал, 16-20 жил ажилласан багшийн даалгаврын гүйцэтгэл 68.9 хувь, 26-аас дээш жил ажилласан багш, албан хаагчдын сорилын даалгаврын үнэлгээ 62 хувь байгаа нь харьцангуй өндөр үнэлгээ юм. Гэтэл 1-5 жил ажиллаж буй багш, ажилтны гүйцэтгэлийн үнэлгээ нь 55.9 хувь байна. Ийнхүү ажилласан жил ба сорилын даалгаврын гүйцэтгэлийн хувь нь харилцан эерэг хамааралтай байгаа нь сонирхолтой үзүүлэлт юм.




График 1. Сорилд хамрагдсан хүмүүсийн монгол бичиг судалсан байдал – гүйцэтгэлийн хувь ба оролцогчдын тоогоор

Дээрх зургаас харахад, ажилласан жил нэмэгдэх тусам даалгаврын гүйцэтгэл сайжирсан байна.

Оролцогчдын монгол бичгийн ур чадварын талаарх өөрийн үнэлгээг үзэхэд ихэнх нь анхан шатны гэж үнэлсэн байна. Тухайн үнэлгээ ба гүйцэтгэлийн онооны хооронд статистик ач холбогдлын ялгаа ажиглагдаж байна ($P < 0.01$).




График 2. Сорилд хамрагдсан оролцогчдын өөрийн үнэлгээ

Өөрийгөө ахисан түвшний мэдлэг чадвартай гэж үнэлсэн багш, ажилтнуудын сорилын даалгаврын үнэлгээ 82 хувь байхад, анхан шатны гэж үзсэн нь 52 хувийн гүйцэтгэлийн үнэлгээтэй байгаа нь нэг талаас оролцогчдын өөрийн үнэлгээ харьцангуй бодитой байгааг харуулж байна.

Асуултад хариулсан байдлаас үзэхэд, ихэнх нь буюу 86 хувь нь компьютерт монгол бичгээр бичих чадвар сул гэжээ. Монгол бичгийн мэдлэг чадвараа дээшлүүлэх шаардлагатай эсэх асуултад судалгаанд оролцогчдын 96 хувь нь шаардлагатай гэжээ. Сургалтын ямар хэлбэр тохиромжтой вэ гэсэн асуултад цахим сүлжээ ашиглаж бие даан мэдлэг чадвараа дээшлүүлэхийг 52.8 хувь нь сонгосон бол хувийн багшаар заалгах сонирхолтой гэж 33.5 хувь, гэрээр суралцах хүсэлтэй 13.5 хувь нь үзжээ.

Монгол бичгийн толь бичиг ашигладаг эсэхийг тандсан асуултад 53.5 хувь нь хэрэглэдэг, 46.5 хувь нь хэрэглэдэггүй гэж хариулсныг гүйцэтгэлтэй холбон үзвэл статистик ач холбогдол бүхий ялгаа ажиглагдаж байна. ($P < 0.01$). Тодруулбал, толь бичиг ашигладаг гэсэн оролцогчдын гүйцэтгэлийн дундаж 66.9 хувь байхад, толь бичиг хэрэглэдэггүй гэж хариулсан оролцогчдынх 54.3 хувь байна. Үүнээс толь бичгийн хэрэглээ нь оролцогчдын бичгийн боловсролын чадамжтай холбоотой байх бүрэн боломжтой гэсэн дүгнэлт хийж болох юм.

2.4. Даалгаврын шинжилгээний үр дүн

Даалгаврын шинжилгээг даалгаврын сонгодог онол, аргачлал (СТТ-Classical test theory) (Fre, 2017)-аар хийлээ. Даалгаврын сонгодог онол (СТТ) нь алдааны тоон үзүүлэлтийг тодорхойлох, хувьсагчдын хоорондын хамаарлыг (жишээ нь, корреляци) засах зэрэг асуудлыг шийдвэрлэхэд зориулагдсан болно. СТТ-ийн үндсэн ойлголтууд нь авах ёстой оноо ба алдааны хувьсагч юм.

Даалгаврыг шинжлэхдээ даалгавар тус бүрийн хүнд хөнгөний зэрэг, ялгах чадвар, хамаарлын коэффициент, найдвартай байдлыг тооцов. Найдвартай байдлын коэффициент 0.873 байгаа нь хангалттай үзүүлэлт юм.

Хүснэгт 2. Даалгаврын шинжилгээний үр дүн

№	Дундаж	Хамгийн бага утга	Хамгийн их утга	Стандарт хазайлт	Хүнд хөнгөний зэрэг	Хүнд хөнгөний зэргийн чанарын түвшин	Ялгах чадвар	Ялгах чадварын чанарын түвшин	Нийт оноотой хамаарах хамаарлын коэффициент	Найдвартай байдал
d1	0.91	0.00	1.00	0.21	90.75	X	16.30	X	.341**	0.873 (Зөвшөөрөгдөх түвшин 0.7-оос дээш)
d2	1.26	0.00	1.50	0.46	84.03	X	34.99	Y	.477**	
d3	1.65	0.00	2.00	0.53	82.69	X	37.71	Y	.612**	
d4	0.48	0.00	1.00	0.50	47.91	Y	49.17	Y	.403**	
d5	0.67	0.00	1.00	0.47	67.16	Y	48.07	Y	.422**	
d6	0.62	0.00	1.00	0.49	61.94	Y	60.77	Y	.501**	
d7	0.38	0.00	1.00	0.49	38.06	Y	39.78	Y	.326**	
d8	0.42	0.00	1.00	0.49	42.39	Y	29.83	Y	.249**	
d9	0.56	0.00	1.00	0.50	55.67	Y	40.33	Y	.344**	
d10	1.63	0.00	2.00	0.49	81.74	X	31.98	Y	.564**	
d11	1.36	0.00	2.00	0.59	68.13	Y	34.81	Y	.496**	
d12	0.59	0.00	1.00	0.49	59.10	Y	70.17	Y	.554**	
d13	0.50	0.00	1.00	0.50	50.00	Y	67.96	Y	.527**	
d14	0.66	0.00	1.00	0.48	65.67	Y	59.12	Y	.461**	
d15	0.39	0.00	1.00	0.49	39.25	Y	49.17	Y	.421**	
d16	1.03	0.00	2.00	0.71	51.46	Y	57.60	Y	.647**	
d17	1.37	0.00	2.00	0.74	68.58	Y	57.87	Y	.650**	
d18	0.50	0.00	1.00	0.50	50.15	Y	49.72	Y	.383**	
d19	1.51	0.00	2.00	0.52	75.34	Y	42.33	Y	.656**	
d20	0.51	0.00	1.00	0.50	51.49	Y	51.38	Y	.411**	
d21	0.71	0.00	1.00	0.46	70.75	Y	44.75	Y	.372**	
d22	0.95	0.00	2.00	0.68	47.39	Y	41.71	Y	.486**	
d23	0.60	0.00	1.00	0.49	60.00	Y	49.17	Y	.404**	
d24	0.41	0.00	1.00	0.49	40.60	Y	48.07	Y	.392**	
d25	1.21	0.00	2.00	0.59	60.52	Y	33.43	Y	.453**	
d26	0.35	0.00	1.00	0.48	34.93	Y	44.20	Y	.368**	
d27	1.34	0.00	2.00	0.77	66.79	Y	55.66	Y	.595**	
d28	1.71	0.00	2.00	0.60	85.52	X	40.19	Y	.597**	
d29	0.39	0.00	1.00	0.49	38.96	Y	46.41	Y	.336**	
d30	0.98	0.00	2.50	0.93	39.01	Y	42.21	Y	.453**	

Нийт	25.65	2	42	7.65	61.06	Ү	44.98	Ү	***p<0.001, **p<0.001,*p<0.05
------	-------	---	----	------	-------	---	-------	---	----------------------------------

***p<0.001,**p<0.001,*p<0.05. Х-Анхаарах, Ү-Зөвшөөрөх

Даалгаврын хүнд хөнгөний зэргийн хувьд, 4 даалгавар хэт хөнгөн бол, ялгах чадварын хувьд 1 даалгавар тохиромжтой бус, харин бүх даалгаврын хамаарлын коэффициент статистик ач холбогдол бүхий ялгаатай байлаа. Өөрөөр хэлбэл, 1 даалгаврыг хасах, 4 даалгаврыг хариултын шинжилгээнд үндэслэн, сайжруулах шаардлагатай байна.

Энэхүү судалгаанд ашигласан даалгавруудад нь нийт хувилбар бүр 30 даалгавар, 42 оноо бүхий дөрвөн хувилбартай. Даалгаврын хэлбэрийн хувьд сонгох-16, харгалзуулах-10, нөхөх-4 даалгавруудаас бүтсэн. Харин танин мэдэхүйн түвшний хувьд ойлгох-8, сэргээн санах-3, үнэлэх-3, хэрэглэх-8, задлан шинжлэх-5, бүтээх-3, даалгавруудаас бүрдсэн. Даалгаврын хэлбэр, танин мэдэхүйн түвшин, нийт гүйцэтгэлээр статистик үзүүлэлтүүдийг Хүснэгт 3-т үзүүлээ.


Хүснэгт 3. Гүйцэтгэлийн дундаж

Даалгаврын ерөнхий статистик		Дундаж	Медиан	Стандарт хазайлт	Вариацийн коэффициент
Хэлбэр	Сонгох гүйцэтгэл	51.15	50.00	22.58	44.14
	Харгалзуулах гүйцэтгэл	65.86	68.42	18.41	27.95
	Нөхөх гүйцэтгэл	70.71	78.57	23.37	33.05
Танин мэдэхүйн түвшин	Үнэлэх гүйцэтгэл	46.12	33.33	33.32	72.25
	Бүтээх гүйцэтгэл	46.58	44.44	28.75	61.72
	Задлан шинжлэх гүйцэтгэл	57.19	57.14	21.30	37.24
	Ойлгох гүйцэтгэл	63.61	65.22	21.16	33.27
	Хэрэглэх гүйцэтгэл	66.48	68.75	21.19	31.87
	Сэргээн санах гүйцэтгэл	71.75	75.00	22.75	31.71
Нийт гүйцэтгэл		61.06	63.10	18.22	29.84

Хүснэгт 3-т үзүүлсэн үр дүнгээс харахад судалгаанд хамрагдсан оролцогчдын монгол бичгийн ур чадварын гүйцэтгэлийн дундаж хувь 61.06(18.22) буюу дундаж түвшинд байна. Хэлбэрийн хувьд сонгох хэлбэрийн даалгавар хамгийн бага гүйцэтгэлтэй (бусад судлагдахуунуудын хувьд сонгох даалгавар хамгийн өндөр гүйцэтгэлтэй гардаг), танин мэдэхүйн түвшний хувьд үнэлэх даалгавар хамгийн бага буюу дундаж нь 46.12(33.32) байна. Үнэлэх даалгаврын медиан – 33.33 (нийт оролцогчийн 50% нь үүнээс доогуур гүйцэтгэлтэй), вариацийн коэффициент нь 72.25 байгаа нь анхаарал татаж байна. Сэдэв боловсруулагч

болон экспертүүд үнэлэх, бүтээх хэлбэрийн даалгаврууд дээр анхаарах шаардлагатай. (Даалгаврын шинжилгээний үр дүнг харар)

Даалгаврууд нь нийт гүйцэтгэлд хэрхэн нөлөөлж байгааг зураг 1-г эрэмбэлж харууллаа.



Зураг 1. Нийт гүйцэтгэлд даалгавруудын нөлөөлж байгаа нөлөөллийн эрэмбэ

3. Дүгнэлт

Энэхүү судалгааг төрийн албан хаагчийн монгол бичгийн мэдлэг чадварыг тандах судалгаанд ашиглах даалгаврын нийцлийг илрүүлэх, түүнд нөлөөлж байгаа хүчин зүйл, ялгаатай байдал, хамаарлыг судлах зорилготой хийлээ. Судалгааны үр дүнгээс дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Гүйцэтгэлийн хувь буюу оролцогчдын монгол бичгийн чадвар 61.06 хувь (18.22) дундаж түвшинд гарлаа.
- Оролцогчдын монгол бичгийн чадварыг хувилбар бүр нь 30 даалгавар бүхий 4 хувилбараар сорьсон бөгөөд зөвшөөрөгдөх түвшинд 25 даалгавар, сайжруулах шаардлагатай 4 даалгавар, хасах шаардлагатай 1 даалгавар байв.
- Нийт гүйцэтгэл нь ялгаатай байгаа эсэхийг шинжлэхэд албан тушаалын байдал нөлөөлөл байхгүй, бусад тохиолдолд буюу мэргэжил, ажилласан жил, нас гэх мэт хүчин зүйлсийн нөлөө байна.
- Даалгаврыг сонгох, харгалзуулах, нөхөх хэлбэрээр, танин мэдэхүйн 6 (сэргээн санах, ойлгох, задлан шинжлэх, хэрэглэх, үнэлэх, бүтээх) түвшнээр боловсруулсан бөгөөд хоорондоо болон нийт гүйцэтгэлтэй хүчтэй, эерэг хамаарлыг үзүүлсэн. Өөрөөр хэлбэл, аль нэг даалгавар дээр гүйцэтгэл сайтай оролцогчдын нийт гүйцэтгэл өндөр хувьтай гарснаас үзэхэд

сорилын даалгаврууд танин мэдэхүйн түвшний хувьд ашиглах боломжтой гэдгийг харуулж байна.

- Даалгавруудын нийцэл, найдвартай байдлын шинжилгээний үр дүн зөвшөөрөгдөх түвшинд гарсны зэрэгцээ, нийт даалгаврын 96.7 хувь нь ашиглах боломжтой, найдвартай байдлын коэффициент шаардлага хангаж байгаа учраас үндсэн судалгаанд ашиглах боломжтой гэж үзэж байна.


Ном зүй

Монгол хэлээр

- Шинэтуяа, Б., Амарзаяа, А.** (2021). Шалгалтын материалыг шинжлэх аргуудыг ашиглах. *Боловсролын тулгамдсан асуудал, шийдэл, арга зам*, 160-166. [Use of Methods of Analysis of Examination Materials] <https://sas.num.edu.mn/>: https://sas.num.edu.mn/mn/wp-content/uploads/2021/04/ISE-2021_PROCEEDINGS-online-1-251-cover-161-167.pdf
- МУЗГ.** (2020). *Үндэсний хөтөлбөр батлах тухай*. Улаанбаатар. Retrieved from <https://legalinfo.mn/mn/detail?lawId=15248> [Ündenii khötölbör batlah tukhai. Resolution of the Government of Mongolia on the approval of the national program]
- УИХ.** (2015). *Монгол хэлний тухай хууль*. Улаанбаатар. Retrieved from <https://legalinfo.mn/mn/detail/10932> [Mongol khelnii tukhai khuuli, Mongolian language law]
- УИХ.** (2020). *Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай*. Улаанбаатар. Retrieved from <https://legalinfo.mn/mn/detail/15584> [Mongol ulsyg 2021-2025 ond khögjүүлэх tavan jiliin ünden chiglel batlakh. Parliamentary resolution on approving the five-year development direction of Mongolia in 2021-2025]
- Отгонбаатар, Х.** (2016). Даалгаврын хариултын онолын 3 параметртэй загварыг ашиглаж тестийн даалгавруудад шинжилгээ хийх нь. *Шинжлэх Ухааны Академийн Мэдээ*, 24-30. [Otgonbaatar, Kh. Analyzing Test Items Using a 3-Parameter Model of Task Response Theory. *News of Mongolian Academy of Sciences*. 2016, 24-30.]
- ХБҮЗ.** (2022). *Бүх нийтийн монгол хэл, бичгийн хэрэглээ, хандлага, үнэлэмжийн судалгаа I*. Улаанбаатар. [HBÜZ. *Bükh niitiin mongol khel, bichgiin khereglee, khandlaga, үнэлэмжийн судалгаа* [Study of Mongolian Language and Writing Usage and Attitudes and Values of the Public]. Улаанбаатар. 2022.]
- УИХ.** (2002.05.03). *Боловсролын тухай хууль*. Улаанбаатар хот. Retrieved from <https://legalinfo.mn/mn/detail/9020> [Bolovsrolyn tukhai khuuli. Education Law]
- УИХ.** (2020). *Алсын хараа 2050*. Улаанбаатар. Retrieved from <https://nda.gov.mn/backend/files> [Alsyn kharaa. Vision Program-2050]

Англи хэлээр

- Fre, F.** (2017). *Test theory, Classical Test theory. International Encyclopedia of Communication Research Methods*. Wiley Blackwell.



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>.